



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрүүл мэндийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2020/172/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Г.Гүнжидмаа Утас: 260512 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 261628 Цахим хаяг: bolormaaj@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Аудитын гэрчилгээ	2
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЭМДС	Эрүүл мэндийг дэмжих сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Я.АМАРЖАРГАЛ ТАНАА

2020.02.21 № 06/553
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрүүл мэндийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Аудитын тайлан

2.1. Оршил

Эрүүл мэндийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Амаржаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн яам 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2/352 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь шударга өрсөлдөөн, сонголтонд суурилсан, аюулгүй, чанартай эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрт олгох олон улсын стандартад нийцсэн нөхцлийг бүрдүүлэх явдал мөн.

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол хүний эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтвортой хөгжлийн зорилт, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын хэрэгжилтийг хангах;
- эрүүл мэндийн салбарын удирдлагын чадавхийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгох;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нийт хүн амд хүргэх, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх чадавхийг бэхжүүлэх;
- яамны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, сайд, Засгийн газрын танхимд үзүүлэх зөвлөгөө, үйлчилгээ, дэмжлэгийг мэргэшлийн өндөр түвшинд хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус яамны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн яам нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Аксплорер программ хангамж ашигладаг байна.

Яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрүүл мэндийн яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 19,878,858.3 мянган төгрөгөөс тооцон 198,788.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 301,334.2 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийн яамны 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,897,710.3 мянган төгрөгөөр буюу 138.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, нөөцийн бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	18,920.8	6,160.8	(12,760.00)
АВЛАГА	182,064.8	1,028,167.7	846,102.86
БАРАА МАТЕРИАЛ	21,368.2	47,528.0	26,159.79
НӨӨЦИЙН БАРАА		1,730,387.0	1,730,387.05
Биет хөрөнгө	4,614,189.3	3,668,948.1	(945,241.19)
Биет бус хөрөнгө	110,283.9	105,089.2	(5,194.68)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,946,827.1	6,586,280.9	1,639,453.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	176,339.0	129,481.2	(46,857.75)
Засгийн газрын хувь оролцоо	2,742,600.5	2,742,600.5	-
Хуримтлагдсан үр дүн	(129,496.3)	1,478,736.4	1,608,232.72
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,157,383.9	2,235,462.7	78,078.86
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	4,946,827.1	6,586,280.9	1,639,453.8

Авлага дансны үлдэгдэл өссөн нь эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээний дагуу Еврофарм ХХК-д 570,000.0 мянган, Си Ай Ти ХХК-д 328,000.1 мянган төгрөг шилжүүлж авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна. Мөн 2017 оны аудитаар тавигдсан актын төлбөрт 1,200.0 мянган төгрөг шилжүүлж хувь хүмүүсээс авах авлагаар бүртгэсэн боловч тодорхой эзэн холбогдогчгүй байгаа нь төлөгдөх найдваргүй болох эрсдэлтэй байна.

Нөөцийн бараа материал дансанд хөрөнгө оруулалтаар худалдан авсан 1,367,487.8 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, өмнөх онд бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байсан түргэн тусламжийн автомашин болон тоног төхөөрөмжийг шилжүүлж бүртгэсэн байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь машин тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй байсан харьяа газруудад хуваарилах тоног төхөөрөмжийг нөөцийн бараа дансанд шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Биет бус хөрөнгийн дансанд өөрчлөлт гараагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн 128,907.6 мянган төгрөгийг бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэлд өөрчлөлт гараагүй байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрүүл мэндийн яам тайлант онд 440,022.4 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 678,862.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 154.3 хувиар биелүүлсэн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 238,840.3 мянган төгрөгөөр давсан нь вакцины орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн бодлого, удирдлага гэсэн 2 хөтөлбөрт зориулан 24,105,169.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 23,221,981.0 мянган төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд, 883,188.5 мянган төгрөгийг урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагджээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 23,991,874.4 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь улсын төсвийн санхүүжилтээс 352,135.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар ДЭМБ-аас 1,215,292.4 мянган, бусад гадаад 4 төсөл хөтөлбөрөөс 867,242.5 мянган, Засгийн газрын нөөц сангаас 1,457,892.1 мянган, БОАЖЯ-наас 524,000.0 мянган, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 255,840.0 мянган, нийт 4,349,944.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс, Засгийн газрын холбогдох тогтоолын дагуу 1,457,891.1 мянган, томуугийн вакцин худалдан авахад 495,496.3 мянган, давсан орлогын зарцуулалт 255,687.6 мянган, холбогдох төсөл хөтөлбөрт 2,138,060.9 мянган, нийт 4,455,199.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 159,633.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 2,170,691.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,063,267.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,346.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 105,077.4 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Өмнөх онд төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 377,719.6 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг бусад үндсэн хөрөнгө дансанд, 318,060.0 мянган төгрөгийн түргэн тусламжийн автомашин болон эмнэлгийн тоног төхөөрөмжийг машин тоног төхөөрөмжийн дансанд, тайлант онд хөрөнгө оруулалтаар худалдан авсан 1,367,487.8 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгслийг бараа материалын дансанд бүртгэсэн нь Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журмын 6.1-д "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ... худалдан авсан тоног төхөөрөмжийн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бусад хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайланд тусгана" гэж заасантай нийцэхгүй байна.

Дээрх хөрөнгөөс 332,880.4 мянган төгрөгийн түргэн тусламжийн автомашин болон эмнэлгийн тоног төхөөрөмжийг ЭМС-ын тушаалын дагуу холбогдох харьяа газруудад

хуваарилж олгосон боловч тухай бүр шилжилт хөдөлгөөн хийж балансаас хасаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "... байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ... аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад нийт 2,063,267.4 мянган төгрөгийн алдааг залруулсан

2. ТНБД-ын 2019 оны 5 дугаар сарын 9, 11-ний өдрүүдийн Б/91, Б/97 дугаар тушаалаар 2 ажилтныг үүрэгт ажлаас нь чөлөөлж 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгосноос нэг ажилтан нь 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс буюу тус яаманд 2 сар орчим ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн 2,346.4 мянган төгрөгийн акт тогтоосон

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Зөөврийн дижитал рентген аппарат нийлүүлэх гэрээний дагуу Еврофарм ХХК-д шилжүүлсэн 570,000.0 мянган төгрөг, угаарын хий хэмжигч, илрүүлэгч багаж нийлүүлэх гэрээний дагуу Си Ай Ти ХХК-д шилжүүлсэн 328,000.1 мянган төгрөгийн гүйцэтгэлийг хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 9 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,665.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 142,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд буюу зөвлөмжийн хэрэгжилт 93.5 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Эрүүл мэндийн яамны 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, стандартын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлснийг Аудитын гэрчилгээнд дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Гадаадад эмчилгээ хийлгэсэн иргэдэд 500,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлснийг холбогдох тушаалуудтай тулган шалгахад үндсэн хагалгааны зардлыг тооцоогүйгээс нэг иргэнд 6,308.0 мянган төгрөгийг нэмж олгосон нь холбогдох тооцооллыг давхар хянадаггүйтэй холбоотой бөгөөд ЭМС-ын 2017 оны А/370 дугаар тушаалаар гадаад эмчилгээний санхүүжилтийн тооцоолол хариуцсан нарийн бичгээр яамны ахлах нягтлан бодогчийг зааж өгсөн нь ажил гүйлгээг гарахаас өмнө төлбөр тооцоог хянах боломжгүй байна.

1.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулах, эмчилгээний зардлыг илүү, дутуу тооцож олгох

1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүргийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг мөрдөж ажиллах

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан ба төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

2. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу хөтөлбөрийн санхүүжилт 120,000.0 мянган төгрөг шилжүүлснээс 19,197.0 мянган төгрөгийн зарцуулалтын тайланг ирүүлээгүй нь хамтран ажиллах гэрээний 4.1.14-д “Гэрээний хэрэгжилт, ажлын тайланг жилд 2 удаа харилцан тайлагнаж, дүгнэж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Гэрээнд заасан ажил бүрэн хэрэгжихгүй байх, тайлант үеийн үр дүн алдаатай илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүргийн 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” гэж заасныг мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан ба төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт

Томилолтын зардлын нийт 76,272.4 мянган, зочин төлөөлөгчдөд гардуулах бэлэг дурсгалын зардлын 3,300.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Эрсдэл

Анхан шатны баримтаар баталгаажаагүй зардлын гүйлгээ гарах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

3.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	222,353,891.31	2,812,243,590.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,920,801.07	6,160,801.07
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	20,801.07	20,801.07
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,900,000.00	6,140,000.00
33	АВЛАГА	182,064,847.44	1,028,167,711.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,665,855.43	0.00
33102	НДШ-ийн авлага	5,665,855.43	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	176,338,992.01	128,907,611.00
33500	Бусад авлага	60,000.00	899,260,100.00
33510	Байгууллагаас авах авлага	60,000.00	898,060,100.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	1,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	21,368,242.80	47,528,030.80
35400	Хангамжийн материал	21,368,242.80	47,528,030.80
35410	Бичиг хэргийн материал	831,000.00	831,000.00
35420	Аж ахуйн материал	12,775,919.00	26,589,169.00
35440	Түлш, шатах тослох материал	-	3,493,948.00
35470	Бусад хангамжийн материал	7,761,323.80	16,613,913.80
36	НӨӨЦИЙН БАРАА	-	1,730,387,047.90
36800	Бусад эргэлтийн хөрөнгө (ТӨҮГ)	-	1,730,387,047.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	4,724,473,201.40	3,774,037,333.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,724,473,201.40	3,774,037,333.78
39200	Биет хөрөнгө	4,614,189,286.14	3,668,948,099.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,762,001,782.94	2,840,080,641.79
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(22,002,828.28)	(189,774,449.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	273,016,610.20	273,016,610.20
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(206,539,393.77)	(235,461,521.29)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,375,060,757.05	2,051,701,282.42
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(1,126,633,215.92)	(1,285,936,080.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	422,593,692.98	451,199,139.71
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(242,549,812.78)	(237,105,242.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	381,262,450.00	3,542,750.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(2,020,756.29)	(2,315,031.33)
39300	Биет бус хөрөнгө	110,283,915.26	105,089,234.15
39301	Програм хангамж	38,317,990.00	38,317,990.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(24,623,614.74)	(29,818,295.85)
39303	Бусад биет бус хөрөнгө	96,589,540.00	96,589,540.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	4,946,827,092.71	6,586,280,924.55
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	176,338,992.01	129,481,243.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	176,338,992.01	129,481,243.01
41300	Өглөг	176,338,992.01	129,481,243.01
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	176,338,992.01	129,481,243.01
413213	Бусад зардлын тооцоо	176,338,992.01	129,481,243.01

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	4,770,488,100.70	6,456,799,681.54
51	Засгийн газрын хувь оролцоо	4,770,488,100.70	6,456,799,681.54
51101	-Төрийн	2,742,600,541.40	2,742,600,541.40
51200	Хуримтлагдсан үр дүн	(129,496,303.07)	1,478,736,418.93
51210	Өмнөх үеийн үр дүн	1,148,185,969.09	566,283,396.91
51220	Тайлант үеийн үр дүн	(1,277,682,272.16)	912,453,022.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,157,383,862.37	2,235,462,721.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	4,946,827,092.71	6,586,280,924.55

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,878,858,323.57	30,140,984,113.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	763,668,983.97	2,137,906,162.00
1200	Нийтлэг татварын бус орлого	627,886,334.00	2,137,906,162.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	627,886,334.00	2,137,906,162.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	622,784,334.00	665,862,785.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	5,102,000.00	13,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	1,459,043,377.00
1220	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	135,782,649.97	-
122001	Хандив тусламж-дотоод	135,782,649.97	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,115,189,339.60	28,003,077,951.81
1310	Улсын төсвөөс	15,452,574,000.00	23,672,709,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,452,574,000.00	23,672,709,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,662,615,339.60	4,330,368,851.81
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,507,065,234.60	2,089,016,661.81
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	2,126,215,281.00	1,457,892,190.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,334,824.00	783,460,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	19,516,777,678.27	28,219,758,924.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,516,777,678.27	28,219,758,924.64
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,618,044,198.20	26,778,938,225.52
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,570,282,925.91	1,757,978,781.16
210101	Үндсэн цалин	1,173,509,401.48	1,062,192,708.44
210102	Нэмэгдэл	243,396,501.83	434,323,379.50
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	141,813,855.60	108,206,672.25
210104	Урамшуулал	11,563,167.00	153,256,020.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,032,753.85	265,559,457.72
210201	Тэтгэврийн даатгал	117,769,373.85	184,213,983.72
210202	Тэтгэмжийн даатгал	18,282,412.00	21,613,208.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,305,397.00	20,054,666.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,835,121.00	5,013,716.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,840,450.00	34,663,884.00

Эрүүл мэндийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	139,820,800.00	112,553,128.00
210301	Гэрэл, цахилгаан	34,073,300.00	34,073,300.00
210302	Түлш, халаалт	32,523,000.00	32,523,000.00
210303	Цэвэр, бохир ус	13,145,500.00	13,145,500.00
210304	Байрны түрээс	60,079,000.00	32,811,328.00
2104	Хангамж, бараа материалын зардал	119,226,093.56	356,876,168.99
210401	Бичиг хэрэг	43,587,560.00	156,084,852.66
210402	Тээвэр, шатахуун	28,580,000.00	112,927,012.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,091,925.56	22,996,919.33
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,740,500.00	1,495,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,846,108.00	6,129,865.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	10,380,000.00	57,242,520.00
2105	Нормативт зардал	12,153,359,241.62	14,749,974,962.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,152,383,241.62	14,598,472,415.10
210502	Хоол, хүнс	-	150,602,547.34
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	976,000.00	900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,299,754.00	257,306,771.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,175,000.00	225,896,000.00
210602	Тавилга	-	1,539,880.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	11,624,754.00	29,670,891.00
2107	Томилолт, зочны зардал	87,059,829.00	291,435,951.79
210701	Гадаад албан томилолт	-	31,006,346.79
210702	Дотоод албан томилолт	87,059,829.00	260,429,605.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,591,436,944.26	7,163,740,638.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,534,532,598.67	7,138,124,578.01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,252,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,289,700.00	1,289,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	574,500.00	501,604.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	260,400.00	2,287,556.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,947,305.59	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	51,802,440.00	19,263,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,751,525,856.00	1,823,512,366.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,267,054,078.15	1,212,792,472.02
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	20,583,303.00	41,153,215.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	463,888,474.85	569,566,679.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	898,733,480.07	1,440,820,699.12
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	299,202,460.07	352,135,429.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	299,202,460.07	352,135,429.72
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	30,726,014.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	30,726,014.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	557,937,568.00	951,479,460.40
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	313,291,554.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	442,969,000.00	499,999,999.40
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,022,854.00	83,205,108.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,945,714.00	54,982,799.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	41,593,452.00	106,479,795.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	362,080,645.30	1,921,225,189.17
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	200,000.00	1,876,000.00
14	ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО	200,000.00	1,876,000.00
140	Төсөвт байгууллагын орлого	200,000.00	1,876,000.00
140020	Данс орлого	200,000.00	1,876,000.00
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	1,639,962,917.46	1,010,648,167.15
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,639,962,917.46	1,010,648,167.15
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	1,639,962,917.46	1,010,648,167.15
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	926,890,666.87	677,767,715.06
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	713,072,250.59	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	332,880,452.09
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(1,277,682,272.16)	912,453,022.02

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	19,831,208,872.44	28,860,155,728.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	633,540,384.00	679,078,785.00
1200	Нийтлэг татварын бус орлого	633,540,384.00	679,078,785.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	633,540,384.00	679,078,785.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	622,784,334.00	665,862,785.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	10,756,050.00	13,216,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,197,668,488.44	28,181,076,943.82
1310	Улсын төсвөөс	15,452,574,000.00	23,672,709,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,452,574,000.00	23,672,709,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,745,094,488.44	4,508,367,843.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,507,065,234.60	2,258,873,996.82
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөл	82,479,148.84	-

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	2,126,215,281.00	1,457,892,190.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,334,824.00	791,601,657.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	19,031,075,295.03	28,872,915,728.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,031,075,295.03	28,872,915,728.82
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,131,020,821.37	27,293,237,418.70
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,562,663,371.37	1,772,779,186.81
210101	Үндсэн цалин	1,123,717,103.48	1,076,993,114.09
210102	Нэмэгдэл	261,952,607.83	434,323,379.50
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	160,255,537.06	108,206,672.25
210104	Урамшуулал	16,738,123.00	153,256,020.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	193,762,700.00	245,573,196.64
210201	Тэтгэврийн даатгал	115,368,131.00	169,515,652.00
210202	Тэтгэмжийн даатгал	22,972,671.00	19,790,021.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,378,177.00	14,590,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,594,494.00	3,647,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,449,227.00	38,029,123.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	139,820,800.00	111,875,728.00
210301	Гэрэл, цахилгаан	34,073,300.00	34,073,300.00
210302	Түлш, халаалт	32,523,000.00	32,523,000.00
210303	Цэвэр, бохир ус	13,145,500.00	13,145,500.00
210304	Байрны түрээс	60,079,000.00	32,133,928.00
2104	Хангамж, бараа материалын зардал	99,254,093.56	243,100,199.99
210401	Бичиг хэрэг	44,463,560.00	86,014,080.66
210402	Тээвэр, шатахуун	17,997,000.00	118,278,125.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,091,925.56	23,889,079.33
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,510,500.00	1,495,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,191,108.00	13,423,915.00
2105	Нормативт зардал	12,150,539,241.62	14,758,242,582.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,148,938,241.62	14,599,486,815.10
210502	Хоол, хүнс	-	156,891,547.34
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,601,000.00	1,864,220.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,299,754.00	394,241,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,175,000.00	284,963,648.00
210602	Тавилга	-	72,709,061.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	502,500.00
210604	Урсгал засвар	11,624,754.00	36,066,541.00
2107	Томилолт, зочны зардал	88,786,829.00	309,685,951.79
210701	Гадаад албан томилолт	-	18,947,746.79
210702	Дотоод албан томилолт	88,786,829.00	290,738,205.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,587,294,850.67	7,182,422,216.01

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,532,106,498.67	7,125,501,356.01
210803	Даатгалын үйлчилгээ	1,289,700.00	1,289,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	574,500.00	501,604.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	260,400.00	2,287,556.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	221,312.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	52,812,440.00	52,820,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,291,599,181.15	2,275,316,607.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,271,015,878.15	2,233,827,392.02
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	20,583,303.00	41,489,215.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	900,054,473.66	1,579,678,310.12
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	299,202,460.07	481,043,040.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	299,202,460.07	481,043,040.72
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	30,726,014.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	30,726,014.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	557,937,568.00	961,429,460.40
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	323,241,554.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	442,969,000.00	499,999,999.40
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп	85,022,854.00	83,205,108.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,945,714.00	54,982,799.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,320,993.59	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	41,593,452.00	106,479,795.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	800,133,577.41	(12,760,000.00)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	782,578,071.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	782,578,071.00	-
223	БУСАД ХӨРӨНГӨ	782,578,071.00	-
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	782,578,071.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(782,578,071.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	17,555,506.41	(12,760,000.00)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,365,294.66	18,920,801.07
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,920,801.07	6,160,801.07

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,742,600,541.40	2,157,383,862.37	(129,496,303.07)	4,770,488,100.70
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,742,600,541.40	2,157,383,862.37	(129,496,303.07)	4,770,488,100.70
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,742,600,541.40	2,157,383,862.37	(129,496,303.07)	4,770,488,100.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	695,779,699.98	695,779,699.98
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,742,600,541.40	2,157,383,862.37	566,283,396.91	5,466,267,800.68
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	78,078,858.84	-	78,078,858.84
Тайлант үеийн үр дүн	-	-	912,453,022.02	912,453,022.02
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,742,600,541.40	2,235,462,721.21	1,478,736,418.93	6,456,799,681.54

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,112,731,500.00	23,999,436,455.28	465,430,474.44	99.5
УРСГАЛ ЗАРДАЛ	24,112,731,500.00	23,999,436,455.28	465,430,474.44	99.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,229,543,000.00	23,116,477,199.88	113,295,044.72	99.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,807,076,300.00	1,772,779,186.81	34,297,113.19	98.1
Үндсэн цалин	1,088,844,700.00	1,076,993,114.09	11,851,585.91	98.9
Нэмэгдэл	434,519,800.00	434,323,379.50	196,420.50	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	108,235,000.00	108,206,672.25	28,327.75	100.0
Урамшуулал	175,476,800.00	153,256,020.97	22,220,779.03	87.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,212,900.00	245,573,196.64	3,639,703.36	98.5
Тэтгэврийн даатгал	169,464,800.00	169,515,652.00	-50,852.00	100.0
Тэтгэмжийн даатгал	19,937,000.00	19,790,021.64	146,978.36	99.3
ҮОМШӨ-ний даатгал	15,949,700.00	14,590,700.00	1,359,000.00	91.5
Ажилгүйдлийн даатгал	3,987,400.00	3,647,700.00	339,700.00	91.5
Эрүүл мэндийн даатгал	39,874,000.00	38,029,123.00	1,844,877.00	95.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	123,217,800.00	111,875,728.00	11,342,072.00	90.8
Гэрэл, цахилгаан	34,073,300.00	34,073,300.00	0.00	100.0
Түлш, цахилгаан	32,523,000.00	32,523,000.00	0.00	100.0
Цэвэр, бохир ус	13,145,500.00	13,145,500.00	0.00	100.0
Байрны түрээс	43,476,000.00	32,133,928.00	11,342,072.00	73.9
Хангамж, бараа материалын зардал	127,175,600.00	113,821,401.33	13,354,198.67	88.8
Бичиг хэрэг	50,022,700.00	49,774,907.00	247,793.00	99.5
Тээвэр, шатахуун	26,120,500.00	25,620,500.00	500,000.00	97.3

Эрүүл мэндийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,581,900.00	23,507,079.33	4,074,820.67	85.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,555,100.00	1,495,000.00	60,100.00	96.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,895,400.00	13,423,915.00	8,471,485.00	61.3
Нормативт зардал	14,026,660,500.00	14,024,312,693.10	2,347,806.90	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,024,170,500.00	14,022,448,473.10	1,722,026.90	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,490,000.00	1,864,220.00	625,780.00	74.9
Эд хогшил, урсгал засварын зардал	342,662,700.00	337,744,150.00	4,918,550.00	98.6
Багаж, техник хэрэгсэл	228,345,900.00	228,466,048.00	-120,148.00	100.1
Тавилга	74,295,400.00	72,709,061.00	1,586,339.00	97.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	530,800.00	502,500.00	28,300.00	94.7
Урсгал засвар	39,490,600.00	36,066,541.00	3,424,059.00	91.3
Ойёёёё, сi-йi çаdааё	85,017,800.00	78,365,870.00	6,651,930.00	92.2
Дотоод албан томилолт	85,017,800.00	78,365,870.00	6,651,930.00	92.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	6,263,544,000.00	6,252,227,474.00	11,316,526.00	99.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,205,338,700.00	6,195,306,614.00	10,032,086.00	99.8
Даатгалын үйлчилгээ	1,289,700.00	1,289,700.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	574,500.00	501,604.00	72,896.00	87.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	297,000.00	22,000.00	275,000.00	7.4
Газрын төлбөр	2,927,100.00	2,287,556.00	639,544.00	78.2
Банк санхүүгийн байгууллагын	297,000.00		297,000.00	0.0
Улсын мэдээллийн маягт	52,820,000.00	52,820,000.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	204,975,400.00	179,777,500.00	25,197,900.00	87.7
Бараа үйлчилгээний бусад зардал	154,347,400.00	141,109,285.00	13,238,115.00	91.4
Хичээл үйлдвэрлэлийн дагалдах хэрэгсэл	50,628,000.00	38,668,215.00	11,959,785.00	76.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	883,188,500.00	882,959,255.40	229,244.60	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	106,483,200.00	106,479,795.00	3,405.00	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	173,428,200.00	173,291,554.00	136,646.00	99.9
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	500,000,000.00	499,999,999.40	0.60	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	83,277,100.00	83,205,108.00	71,992.00	99.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,000,000.00	19,982,799.00	17,201.00	99.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,112,731,500.00	23,999,436,455.28	113,295,044.72	99.5
Улсын төсвөөс санхүүжих	23,672,709,100.00	23,320,573,670.28	352,135,429.72	98.5
Төсвийн байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	440,022,400.00	678,862,785.00	(238,840,385.00)	154.3
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
АЖИЛЛАГСАДЫН ТОО	100	100		
Удирдах ажилтан	3	3		
Гүйцэтгэх ажилтан	97	97		

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /төгрөгөөр/
ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,349,944,218.82
Улсын төсвөөс		4,349,944,218.82
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		2,632,386,525.82
Засгийн газрын нөөц сан		1,457,892,190.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		18,616,500.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		241,049,003.00
ҮНДСЭН Ү/А-НЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		4,349,944,218.82
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,349,944,218.82
Хангамж, бараа материалын зардал		129,278,798.66
Бичиг хэрэг		36,239,173.66
Тээвэр, шатахуун		92,657,625.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		382,000.00
Нормативт зардал		733,929,889.34
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		577,038,342.00
Хоол, хүнс		156,891,547.34
Эд хогшил, урсгал засварын зардал		56,497,600.00
Багаж, техник хэрэгсэл		56,497,600.00
Томилолт, зочны зардал		231,320,081.79
Гадаад албан томиллолт		18,947,746.79
Дотоод албан томиллолт		212,372,335.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж		917,434,742.01
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		917,434,742.01
Бараа үйлчилгээний бусад зардал		2,096,533,107.02
Бараа үйлчилгээний бусад зардал		636,035,917.02
Бараа үйлчилгээний бусад зардал /81101/		1,457,892,190.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,605,000.00
Бусад урсгал шилжүүлэг		184,950,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		149,950,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		35,000,000.00

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020-02-21	Аудитын нэр:	<i>Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ			САГ-2020/172/СТА-ТШЗ
				Мянган төгрөгөөр

Д Д	Аудитын зорилт, чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Албан тушаал	Овог нэр
	1		2	3	4	5
1	Тэтгэмжийн зардал	3 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг үндэслэлгүй олгосон	2,346.4	Акт	ТНБД Нягтлан бодогч	Я.Амаржаргал Х.Ариунтуяа
2	Зардлын данс	Гадаад эмчилгээний зардал зөрүүтэй олгосон	6,308.0	Зөвлөмж		
3	Гэрээний биелэлт	Гэрээний хэрэгжилт дүгнээгүй	19,197.0	Зөвлөмж		
4	Анхан шатны баримтын бүрдэл	Гадаад, дотоод томилолтын зардал, бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан баримтын бүрдэл дутуу	79,572.4	Зөвлөмж		
		ДҮН	107,423.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2019 оны 12 дугаар сарын 23

№ 05/131

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Эрүүл мэндийн яамны 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Цасчимэг нь 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс тус яаманд ажилд орж 2 сар ажилласан боловч ТНБД-ын 2019 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн Б/97 дугаар тушаалаар үүрэгт ажлаас нь чөлөөлж, 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний буюу 2,346,449 төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-д “нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ө.Цасчимэгт олгосон 2,346,449 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь 100900000601 тоот дансанд 2020 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн дотор төвлөрүүлэх
2. Биелэлтийг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Амаржаргал, Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Эрдэмбилэг нарт даалгав.

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР
Ж.БОЛОРМАА

АКТЫГ:

ЗӨВШӨӨРСӨН:
ЭМЯ-НЫ ТНБД-ЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Я.АМАРЖАРГАЛ
ЭЗСХО-ЫН ГАЗРЫН ДАРГА
Г.ЭРДЭМБИЛЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь таслах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2019\1212SAG2.Docx

070391